



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/446

Мандагзовь

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс ажиллуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Сайнцагаан сумын 10, 11 дүгээр байрны гадна фасадны засварын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Э.Энхмэнд	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	Н.Эрдэнэбат	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)
	Б.Доржхорол	(Аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтэн)
	Б.Хосбаяр	("Арткон" ХХК-ийн архитектор)
	Д.Баттөгс	("Зуут констракшн" ХХК-ийн захирал)
	Э.Солонго	("Зуут констракшн" ХХК-ийн менежер)
	Р.Мөнхтогтох	(Сайнцагаан сумын Засаг дарга)
	Д.Эрдэнэболд	(Сайнцагаан сумын 10 дугаар байрны оршин суугч)
	Н.Сүхбаатар	(Сайнцагаан сумын 11 дүгээр байрны оршин суугч)
	П.Алтанчимэг	(Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дарга)

Хоёр. Засварын ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлт гарган, архивт хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

433010399